




НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР

# ХУУЛЬ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТЭС 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН



ЗӨРЧЛИЙГ АРИЛГАЖ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ

# АГУУЛГА


---

- › *ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР*
- › *ШҮҮХИЙН ШАТАНД*
- › *ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ*
- › *ДҮГНЭЛТ*




## ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР


БАРИЛГА УГСРАЛТЫН  
АЖЛЫН ГЭРЭЭ




ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ



ЗОХИОГЧИЙН  
ХЯНАЛТЫН ГЭРЭЭ



ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА  
СУНГАСАН



БАРЬЦАА  
ЧӨЛӨӨЛҮҮЛЭХ ХҮСЭЛТ




НИЙТ: 1366 ажил

Давхардсан тоогоор

2019 оны 01 дүгээр сарын 02-ноос 2019 оны 12 дугаар сарын 9-ны өдрийг хүртэл нийт 1300 /давхардсан тоогоор/ гэрээг хянасан байна. Үүнээс Барилга угсралтын ажлын гэрээ-710, зөвлөх үйлчилгээний гэрээ-40, Зохиогчийн хяналтын гэрээ-310, Барилга угсралтын гэрээний хугацаа сунгасан-79, барьцаа чөлөөлүүлэх хүсэлт -227 тус тус хянаж бүртгэсэн байна.




## ШҮҮХИЙН ШАТАНД




БУЦААГДСАН

Ажлын тоо: 2 ажил




АНХАН ШАТНЫ  
ШҮҮХЭД

Ажлын тоо: 4 ажил



УЛСЫН ДЭЭД  
ШҮҮХЭД

Ажлын тоо: 1 ажил



ЭЦЭСЛЭН  
ШИЙДВЭРЛЭГДСЭН

Ажлын тоо: 11 ажил

- Иргэний хэргийн шүүхийн шатанд нийт 18 хэрэг маргаан байгаас эцэслэн шийдвэрлэгдсэн 11, анхан шатны шүүхийн шатанд 4 хэрэг, буцаагдсан-2, Улсын дээд шүүхэд 1 хэрэг байна



## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Ажлын төрөл	Ажлын тоо
1	Барилга угсралт	137
2	Инженерийн шугам сүлжээ	97
3	Зураг төсөв	33
4	Тохижилт	69
5	Их засвар	191
6	Гэрэлтүүлэг, камержуулалт	26
7	Цахилгаан	51
8	Тоног төхөөрөмж	3
9	Авто зам	3

- 2019 оны жилийн эцсийн байдалаар улсын болон нийслэл, дүүрэг орон нутгийн хөгжлийн сан, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний давхардсан тоогоор 660 явцын болон эцсийн гүйцэтгэлийг хянасан байна. Үүнээс Барилга угсралтын ажил-137 , инженерийн шугам сүлжээ- 97, зураг төсвийн 33, тохижилтын ажил-69, их засварын ажил-191, гэрэлтүүлэг, камержуулалтын 26, цахилгааны-51, тоног төхөөрөмжийн-3 ажилуудийг тус тус хянасан байна.



## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

	Дүүрэг	Ажлын тоо	Гэрээний дүн /сая төгрөг/
1	Баянзүрх	2	1,609.6
2	Сүхбаатар	2	5,189.9
3	Чингэлтэй	5	9,376.5
4	Хан-Уул	4	2,009.6
5	Сонгинохайрхан	6	15,003.7
6	Багануур	2	13,380.9
7	Багахангай	2	798.8
8	Налайх	2	12,082.3
9	Баянгол	6	15,919.5
	НИЙТ	31	75,370.8

- 2019 оны 11 дүгээр сард газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлагдсан хуваарийн дагуу газрын хэмжээнд хэрэгжүүлж буй нийт 31 төсөл арга хэмжээний хэрэжилтийн явцад хяналт шалгалт хийж тайлан гарган ажилласан байна.



## ДҮГНЭЛТ

# 1

2019 онд хийгдээд байгаа дотоод хяналтын төлөвлөгөөт болон чиглэсэн шалгалтын үр дүнгээс харахад барилга угсралтын ажлын гэрээ хийхдээ гүйцэтгэгч байгууллага ажил гүйцэтгэх хуваариа бодитой хийж ирүүлээгүй, хугацаа давчуу хийгддэг зэргээс хамааралтай хийгдсэн ажлын технологийн горим зөрчигдсөн алдаа зөрчил гарч байна. Түүнчлэн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх явцад гүйцэтгэгч компани нь мэргэжлийн инженер техникийн ажилчид, ажиллах хүч дутмаг, туслан гүйцэтгэгчээр ажлаа гүйцэтгүүлдэг, дотоод хяналт шалгалтыг хийдэггүй, ажлын талбайн зохион байгуулалт муугаас ажлын чанартай холбоотой зөрчил дутагдлууд байнга илэрч, чанаргүй ажлуудыг эргэн засварлуулах байдлаар ажлаа гүйцэтгэж байгаа нь барилгын ажил үргэлжлэх хугацаа, чанарт нөлөөлж байна.

# 2

Эрх зүйн чиглэлээр гэрээ болон гүйцэтгэлийн хяналтыг хийж илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг тухай бүрд нь засаж байна. Дараах алдаа зөрчил нийтлэг гарч байна. хуулийн этгээдтэй гэрээ байгуулахдаа хуулийн этгээдийн үндсэн бичиг баримт болох хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийг шалгаж гэрээ хийдэггүй, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийг шалгадаггүй, хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрмийг шинэчлээгүй зэрэг зөрчлүүд илэрч байна. Дээрх алдаа зөрчлийг арилгаснаар шүүхэд энэ төрлийн маргаан гарах эрсдлээс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

# 3

Хууль дотоод хяналтын хэлтэс нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн гэрээний хяналт болон дотоод хяналтыг 100% хийж гүйцэтгэв.

# 4

Иймд цаашид анх гэрээ байгуулахдаа хуулийн этгээдийн үндсэн бичиг баримт болох хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийг шалгаж гэрээ хийх, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийг шалгах, ажил гүйцэтгэх хуваарь, гэрээний хугацааг тухайн ажлын технологийн хугацаатай уялдуулан үнэн зөв хийх, технологи дараалал, хугацааг мөрдүүлэх, гүйцэтгэгч компанийн тендерийн материалд ирүүлсэн голлох инженер техникийн ажилтнуудаар ажил гүйцэтгүүлэх зэрэг шаардлагыг мөрдөж ажиллах.